

“Таван хошуу малын магтаал” хэмээх аман яруу найргийн эх бичвэрийн судалгаа

Ринчингийн Чүлтэмсүрэн 

Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Утга зохиолын тэнхимийн багш, доктор (Ph.D), профессор, Улаанбаатар, Монгол Улс

Батбилэгийн Надмид 

Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Утга зохиолын тэнхимийн багш, доктор (Ph.D) Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2025- 11-14

Засварласан - Revised:
2025-12-25

Хэвлэгдсэн - Published:
2025-12-31

chultemsuren@msue.edu.mn
ORCID: 0009-0003-2059-212X

nadmid@msue.edu.mn
ORCID: [0009-0005-9966-6113](https://orcid.org/0009-0005-9966-6113)



© 2025, Author(s)

Хураангуй: Монгол аман зохиолд магтаалын төрөл зүйл онцгой байр суурь эзэлдэг. Нүүдэлчин монголчууд малчин түмний биет бус соёлын өв болсон магтаал нь уул ус, гэр орон, мал сүрэг, эдлэл хэрэгсэл зэрэг бүхий л зүйлээ үгийн сайнаар магтаж, бэлгэдэн ерөөдөг нь монгол үндэстний өвөрмөц шинж (mentality) билээ. Монгол аман зохиолын үндэстний өвөрмөц онцлог шинж, нүүдэлчдийн сэтгэлгээ, бэлгэдэх ёс нь энэхүү төрөл зүйлд тод харагддаг юм. Магтаалын аман яруу найргийн олон эх бичвэр Монгол аман зохиолын үндэстний өвөрмөц онцлог шинж, нүүдэлчдийн сэтгэлгээ, бэлгэдэх ёс нь энэхүү төрөл зүйлд тод харагддаг юм. Магтаалын аман яруу найргийн олон эх бичвэр зохиогдсноос гадна үе үеийн алдартай магтаалчид монгол үндэстэн, монгол угсаатны дундаас төрөн гарсан байдаг. гадна үе үеийн алдартай магтаалчид монгол үндэстэн, монгол угсаатны дундаас төрөн гарсан байдаг. Тийм магтаалчдын нэгэн нь одоогийн Дундговь аймгийн Гурвансайхан сумын уугуул ерөөлч, магтаалч С.Үржинханд

(1910-1993) юм. Тэрбээр “Гэрийн ерөөл”, “Хуримын ерөөл”, “Таван хошуу малын магтаал”, “Нэгдлийн магтаал” зэрэг өргөн сэдэв бүхий урын сантай, XX зууны монгол үндэстний шилдэг ерөөлч, магтаалч билээ. Энэхүү өгүүлэлд түүний “Таван хошуу малын магтаал”-ын эх бичвэрийн гол агуулга, уран дүрслэл, зохиомж зэргийг нь уламжлал, шинэчлэлийн хүрээнд нь ажиглан дүгнэлт хийлээ. Тэгэхдээ хуучны Түшээт хан аймгийн Дайчин бээсийн хошуу одоогийн Дундговь аймгийн Гурван сайхан сумын уугуул Мэндбаярын Цэдэв (1892-1937) тайжаас уламжилсан “Таван хошуу малын мэнд мэдэх тухай” хэмээх гар бичмэл магтаалын эх бичвэртэй уламжлал шинэчлэлийн нь үүднээс харьцуулан ажиглав.

Түлхүүр үг: С.Үржинханд, таван хошуу мал, магтаал, ерөөл, магтаал

1. Оршил

Ерөөлч, магтаалч С.Үржинханд нь хуучны Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошуу одоогийн Дундговь аймгийн Гурвансайхан суманд 1910 онд төржээ. Тэрбээр төрөлхийн урлагийн их авьяастай, сэцэн цэлмэг үг хэлтэй, ардын биет бус соёлын өвийг тээгч, аман яруу найрагч хүн байжээ. Малчин ахуйдаа насан туршаа амьдарч ирсэн, аман яруу найраг зохиож туурвих гоц авьяас билгээ уйгагүй хөдөлмөрөөр тэтгэсэн хүн байлаа. С.Үржинханд нь уран сэтгэмж сайтай, цэцлэх чадвараар гоц, монгол ерөөлч, магтаалч хүний гол шинж нь болсон аливаа зүйлийг ерөөх, магтахдаа харснаа газар дээр нь шууд уран яруу цэцлэн хэлдэг авьяастан байжээ. Тийм чадварлаг хэмжээнд хүрэхэд бас мэдлэг, өмнөх өв соёлоос

бүтээлчээр суралцах, олон жилийн дадлага туршлага хэрэгтэй. Аман зохиол судлаачид бид ерөөл, магтаалын эх бичвэр, төрөл зүйл, туурвил зүйг судлахаас гадна ерөөлч магтаалчдын урын сан, цэцлэх чадвар, амьдрал намтрыг нь ч шинжлэн аман зохиолын түүхэнд байр суурийг нь эзлүүлэх ёстой. Ерөөл, магтаалын эх бичвэр, аман ба бичгийн эх сурвалж арвин байдаг ч ерөөлч, магтаалчдын тухай тус бүрд нь судлан шинжилсэн эрдэм шинжилгээний бүтээл цөөн. Иймд бид С.Үржинханд хэмээх ерөөлч, магтаалчийн өмнөх ахмад аман билигтнүүдээс хэрхэн суралцсан, магтаалынх нь аман яруу найргийн уламжлал хийгээд шинэчлэлийг нь шинжлэн судлах зорилго тавив.

2. Арга зүй

Энэхүү судалгаанд эх бичвэрийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, уламжлал, шинэчлэлийг нь харьцуулах арга зүйг гол болгов. Ингэхдээ С.Үржинхандын зохиосон “Таван хошуу малын магтаал”-ыг (Үржинханд.С, 2014) М.Цэдэв тайжаас уламжлан ирсэн “Таван хошуу малын мэнд мэдэх тухай” гэсэн бичмэл эхтэй харьцуулан үзэж, үүсэл, уламжлал, дүр, дүрслэл, үг хэллэг, бүтэц зохиомж, агуулгын төстэй ба ялгаатай шинжүүдийг ажиглан задлан шинжлэхийг хичээв.

С.Үржинхандын зохиосон “Таван хошуу малын магтаал”-ын Уламжлал, шинэчлэл

Хоёр эх бичвэрийг уламжлал, шинэчлэлийн хүрээнд нь харьцуулснаар С.Үржинханд магтаалчийн туурвин зохиох чадварын өвөрмөц онцлогийг үндсэндээ тодрууллаа. Түүний ерөөл, магтаалын урын санд “Таван хошуу малын магтаал” нь онцгой байр суурьтай.

Ер нь ерөөл, магтаалын төрөл зүйлийн судалгаанд “Таван хошуу малын магтаал”-ыг дэлгэрэнгүй судалж бараг амжаагүй байгаа бөгөөд Х.Нямбуу (1983), Ц.Өлзийхутаг (1989), Б.Катуу (2011) нар “Таван хошуу малын магтаал”-ын цөөн эх бичвэрийг л эмхэтгэн хэвлүүлжээ. Тэдгээрээс өөр эх бичвэр ховор байна.

Монгол угсаатны аман зохиолд таван хошуу малаа магтаах, ерөөх аман билиг, зан үйл байдаг нь үндэсний ахуй, нүүдэлчин малчдын зан үйлийн онцлог тод жишээ болдог тул тийм сэдэв, өгүүлэмжтэй магтаалыг гүнзгийрүүлэн судлах ёстой.

2.1. “Таван хошуу малын мэнд мэдэх тухай” магтаал, С.Үржинхандын “Таван хошуу малын магтаал”-д нөлөөлсөн нь

“Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошууны (одоогийн Дундговь аймгийн Гурван сайхан сум) Мэндбаяр туслагчийн хүү Цэдэв тайжийн “Таван хошуу [хошуу] малын мэнд мэдэх тухай” хэмээх гар бичмэл эх бичвэр тэдний угсааны Д.Лувсанданзанд хадгалагдаж байсан тухай түүхийн ухааны доктор Ш.Сонинбаяр гавж анх мэдээлсэн юм.

“Энэ судрын дотор малч монгол түмний малаа эрхэмлэн дээдлэх сайхан уламжлалыг тод томруун илтгэн харуулжээ. Малчин ардын зан заншил, аман ба бичгийн малын холбогдолтой хууч домог болон хөдөөгийн ард түмний сэтгэлгээний соёлыг судлахад үлэмжхэн ач холбогдолтой болов уу гэж монгол эхээс нь буулган сийрүүлье” хэмээн Ш.Сонинбаяр гавж онцлон тэмдэглээд, судалгааны хүрээнд оруулсан гавьяатай билээ.

Дараа нь тэдний удмын, нэрт зохиолч, эрдэмтэн Долгорын Цэнджав энэ магтаалын талаар бүр тодруулан нийтийн хүртээл болгоод байна.

Мэндбаярын Цэдэв нь төрсөн нутагтаа Цэдэв тайж, Цэдэв тэргүүн, Цэдэв ерөнхий, Цэдэв бичээч хэмээн алдаршин хүндлэгдэж ирсэн алтан ургийн удамт тайж язгууртан, бичгийн хүн байжээ. Тэрбээр 1892 онд мэндэлж, 1937 онд 45 настайдаа хилс хэргээр цаазлуулсан байна.

М.Цэдэв тайж ерөөл магтаал хэлдэг, зохиодог, бичгийн хүний ёсоор судар номд тэмдэглэн уламжлуулдаг бичгийн их боловсролтой, аман билигтэн юм.

Шинэ цагийн ерөөлч, магтаалч С.Үржинханд М.Цэдэв тайжтай нэг хошууны хүн бөгөөд дээр үеэс М.Цэдэв тайжаас уламжилсан дээрх магтаалыг найр хурим, жасаа даллага, тахилга тайлгын зан үйлд өтгөс, ерөөлч, магтаалчид хэлж байсныг нь бага балчраасаа сонсож өссөн байна. Судраар уламжлагдсан тэрхүү бичгийн эх сурвалжийг нь ч уншиж танилцаж байсан бололтой.

М.Цэдэв тайжийн удамд хадгалагдаж байгаа тэрхүү магтаал нь олон түмний дунд амаар тархсан, бичгээр хуулан авсан, бүрэн ба бүрэн бус эх бичвэр одоо ч Дундговь аймгийн Гурвансайхан сумын уугуул иргэдээс олдож магадгүй тул сурвалжлан хайх хэрэгтэй байна. Уг магтаалыг өвлөн уламжлагч М.Цэдэв тайжийн намтар (Цэнджав.Д, 2023), удам судрын талаар профессор До.Цэнджавын хэрхэн тодорхойлсныг товч дурдъя. Үүнд:

“Эл судрыг [“Таван хошуу малын мэнд мэдэх тухай”] зохиогч [нь] Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошууны туслагч бөгөөд хошууны тамгыг баригч Мэндбаярын төрсөн хүү “ерөнхий” хэмээх Цэдэв тайж мөн болно” (Цэнджав.Долгорын, 2023:54) гэжээ.

- 1) Мэндбаярын Цэдэв тайж
- 2) Мэндбаярын Чоймбол гавж
- 3) Мэндбаярын Юндэн тойн
- 4) Мэндбаярын Лувсандорж лам
- 5) Мэндбаярын Зундуй лам нар 1937 онд хилс хэргээр гүтгэгдэж цаазлуулж байжээ.

М.Цэдэв тайжийн охин Ц.Долгор, Ц.Бүжээ нар эцгийнхээ ном судрыг хадгалж байгаад зохиолч, Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн Долгорын Цэнджав, Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн нэт сэтгүүлч Долгорын Чулуунбаатар нарын төрсөн ах дүү, Цэдэвийн Долгорын дунд хүү Долгорын Лувсанданзанд дээрх судар өвлөгдөн үрэгдэлгүй үлджээ.

2.2. “Таван хошуу малын мэнд мэдэх тухай” магтаал, “Таван хошуу малын магтаал” –ийн дүр, дүрслэлийн харьцуулал

Эдгээр магтаал нь сонгодог магтаал, ерөөлийн дүрслэл, үг хэллэгтэй бөгөөд С.Үржинхандын магтаал нь орчин цагийн ахуй, нийгэм улс төрийн нөлөө бүхий шинэ, хуучин ерөөлийн дүр, дүрслэл сүлэлдэн зохиогдсон байдаг.

Хүснэгт 1. Хонин сүргээ магтсан нь

Таван хошуу малын мэнд мэдэх тухай магтаалд	С.Үржинхандын Таван хошуу малын магтаалд
Шар халзан, хар халзан Хар түрүүт, улаан хүзүүт Бор халзан, хундан цагаан <u>Тавгийн чинээ сүүлтэй</u> Тарган тарган цагаан Ирэг бүхий идрүүд мэнд үү? Жил жилийн төл огт алддаггүй Эрх үйзэн эмгэн хониуд хийгээд Зусаг төлөг хэнз хавчрай Ер хонины сүрэг бүхий мэнд үү? Цэнджав, Д. (2023:59)	Хороо хотоо чимэглэсэн Хонхор дүүрэн бялхсан Хонгор сүү нь мэлтэлсэн Хоормог тараг нь дэлгэрсэн Хотолж ирдэг Хорж зогсдог Хоргой магнаг шиг өнгөтэй Хонин сүрэг нь... <u>Хавтгай дөрвөлжин ууцтай</u> Халбагар дугараг сүүлтэй Таана ногоо ханхалсан Тавар товар хивсэн Тарайж тэрийж ярагласан Тарга хүч нь чихэлдсэн Тариа будаа шиг үржсэн Тансаг баян сүрэг юм Үржинханд, С. (2014:24)

Цэдэв тайж хонин сүргийг магтахдаа эцэг мал хуцаас нь эхэлж:

Дугараг эвэртэй, дун бүрээ шинжтэй

Цагариг эвэртэй, цагаан үстэй

Төгрөг эвэртэй, төө үстэй

Хонины хаан хуц мэргэн дайчин мэнд үү?

хэмээн магтжээ. Цааш нь хонин сүргээ өнгө зүсээр нь тарга хүчийг нь тавгийн чинээ сүүлтэй ирэг гээд төл огт алддаггүй эмгэн хөгшин хонийг нэрлэжээ. Энэхүү магтаалд хуц, ирэг, зусаг төлөг, хэнз хавчрай гэж насаар нь нэрлэсэн байна.

С.Үржинхандын Таван хошуу малын магтаалд:

Хонин сүргийг магтахдаа монгол аман яруу найргийн шүлэглэл зүйн онцлогоор толгой, сүүл холбож, айзам төгс зохиосон уран шүлэг бүтээсэн байна. Хонин сүргийн буян шим, хороо хотоо чимдэг, өнтэй тарган орсон хонины өнгө, хөдөлгөөн, тариа будаа шиг үрждэг буяныг нь тоочиж өмнөх уламжлалыг дүр дүрслэлээр баяжуулжээ.

Цэдэв тайжийн цаг үеийг бодвол нэгдлийн хонин сүрэг, социализмын үеийн ахуйг магтаж байгаа XX зууны магтаалч болохоор шинэ үг хэллэг, мэргэжлийн үг хэллэгийн дүрслэлээр шинэчлэл хийж урлан магтжээ. Тухайлбал:

Хөлөөр хөглөрсөн хэвтэртэй

Анагаах ухааны эмнэлэгтэй

Хөрөв нялхын тасалгаатай

Хөвөн зөөлөн ноосоороо

Уут угжны бэлтгэлтэй

Хөрслөг дулаан арьсаараа

Уурхайн дулаалсан худагтай

Хөлдүү түүхий эдээрээ

Ариун цэврийн хэрэглэлтэй

Үйлдвэрлэлийн төлөвлөгөөг хангах

Үнэт сайхан бараа болж

Олон зуугаар суурилсан

Ард түмнээ хангадаг...

Овоо толгод бүрхсэн

Хашир малчин эзэнтэй

Ойр холын хариулгатай

Хариулаг муудвал осолтой

Олон сэлдэг бэлчээртэй гэжээ

Дээрх С.Үржинхандын магтаалд хонин сүрэг нь боловсон хашаа саравчтай, шинэ цагийн тэргүүний малчдын туршлагаар хургаа хөрвийн аргаар бойжуулдаг тул хөрөв нялхын тасалгаатай. Хургандаа угжаар сүү өгдөг, уурхайн худгаас усалдаг, ариун цэврийн хэрэглэлтэй, малын эмчтэй, хариулга маллагаа сайтай, отор нүүдэл хийдэг (олон сэлдэг бэлчээртэй), түүхий эд, үйлдвэрлэлийн төлөвлөгөө биелүүлэх зэрэг албаны болон мэргэжлийн үг хэллэгийг аятай зүйтэй холбож, шинэ үзэл санаа бүхий агуулгыг илэрхийлж, шинэ үгсийн санг магтаалдаа өгүүлжээ. Энэ бүхэн нь шинэчлэл юм.

Хүснэгт №2 Ямаан сүргээ магтсан нь

Таван хошуу малын мэнд мэдэх тухай магтаалд	С.Үржинхандын Таван хошуу малын магтаалд
Газар чирэм сэвэг зогдортой Галзуурсан их дочигтой Ганц сав хогшилтой <u>Сэлэм шиг эвэртэй</u> Сэрэмгий мэргэн ямааны ноён Ухна жонон эрх үйзэн идэр ланс мэнд үү? Галын сэтэрт хөх сэрх Алж иддэг үгүй алаг сэрх Арилжаанд зардаг үгүй орог сэрх Алба ахуй аль юманд зардаг Амь олон сэрхэн ямаад бүхий мэнд үү? Өнтэй жил гурав дахин <u>хэнзэлж</u> <u>Хачрайлан, дахлайлан</u> ишиглэдэг Өн үгүй жил магад хоёр алдах үгүй ишиглэдэг Үнээ мэт дэлэнтэй Бүрээ мэт уянгалсан дуутай Эрх үйзэн эмгэн ямаа суутнууд хийгээд Тэргүүлж явдаг түгжир хув ишиг Онцгойлж явдаг орог саарал ишиг Захад явдаг загал буурал ишиг Хамуу годронгийн аюул бүгдээс гэтлэгсэн Хамаг олон ямаанууд мэнд үү? Цэнджав, Д. (2023:59)	Гартаам алаг зүстэй Ганган хээнцэр маягтай Хонинд ээлтэй Хотонд бараатай <u>Сэлмэн жадан эвэртэй</u> Сээтэн босоо чихтэй Сэргэлэн цовоо байдалтай Шингэн нарийхан дуутай Уураг сүү арвинтай Удам төрөл олонтой <u>Ихэр голдуу ишиглэдэг</u> <u>Ишиг нь ч гэсэн төллөдөг</u> Сувд эрдэнэ шиг ноолууртай Шуурхай хөнгөн хөдөлгөөнтэй Хонийг баахан дагууламтгай Хорооны мухар эзлэмтгий Нөмрийг түргэн оломтгой Нөхрийг жаахан гадуурхамтгай Хажиг уцаар маягтай Хавьтаж ойртсоноо мөргөх шиг Хазаж чангааж тавих шиг Асга хаданд авирамтгай Амтат ургамлыг шилэмтгий Дуу дуугаараа төллөсөн <u>Дулаан хашаанд байрласан</u> Тэвгэн бутан сахалтай Тэсвэр хатуужил муухантай Торомгор хөөрхөн нүдтэй Тоодгор хөөрхөн сүүлтэй Тохиллог баян сүрэг юм гэжээ. Үржинханд, С. (2014:25-26)

Цэдэв тайж ямаан сүргийг магтахдаа эцэг мал ухнаас нь эхэлжээ. Сахлын нь уртыг “Газар чирэм сэвэг зогдортой гэжээ. Тэмээний зогдор гэдэг ойлголт өдгөө байдаг бол ухнын дүрд сэвэг зогдор гэсэн дүрслэл гарч байна. Ухныг “Ганц сав хогшилтой” гэсэн хошин дүрслэл ч байна.

Сэлэм шиг эвэртэй

Сэрэмгий мэргэн ямааны ноён

Ухна жонон эрх үйзэн идэр ланс гэжээ.

Эврийг нь сэлэм шиг эвэртэй гэдэг уламжлалт дүрслэлийг С.Үржинханд сэлэм жадан эвэртэй гэж шинэчилжээ. Шинэ цагийн хүйтэн зэвсэг жадтай буу үүрч хил хязгаараа манан хамгаалж явсан ахмад дайчны амнаас ийм дүрслэл урган гарах ёстой нь мэдээж. Хуучин цагийн цахиур бууны үзүүрт жад байгаагүй тул ирт сэлмээрээ эврийг нь Цэдэв тайж зүйрлэсэн байж таарна.

Ер нь Цэдэв тайж мал бүрд хэргэм зэрэг олгон дүрсэлжээ. Тэрбээр буур атыг хурц билигт, азаргыг аварга жанжин эрх үйзэн, бүдүүн хүзүүт их хүрэн бухыг жонон эрх үйзэн идэр зайсан, хуцыг хонины хаан хуц мэргэн дайчин, ухныг ямааны ноён, жонон эрх үйзэн идэр ланс гэжээ.

Далимд хэлэхэд ухна бол эцэг малаас ганцаараа сахалтай, эвэртэй тул буг чөтгөр ч айдаг тул хүүхдэдээ дом болгон говийн аймгийнхан Ухна, Ухнаа (А.Д.Цендина, 2025) гэдэг нэр их өгдөг. Түүнийгээ ялгах гэж баахан хоч өгдгийг бид мэднэ. Цэдэв тайжийн магтаалд:

Галын сэтэрт хөх сэрх

Алж иддэг үгүй алаг сэрх

Арилжаанд зардаг үгүй орог сэрх

гэсэн дүрслэлээс хөх, алаг, орог зүсмийн сэрхийг сэтэрлэдэг, алаг, орог сэрх тэр айлын буйан хишгийг хадгалдаг гэсэн ойлголт байх шиг санагдаж байна.

Цэдэв тайж үржил төл сайт эм ямаагаа:

Өнтэй жил гурав дахин хэнзэлж

Хачрайлан, дахлайлан ишиглэдэг

Өн үгүй жил магад хоёр алдах үгүй ишиглэдэг гэжээ

Хачрайлан, дахлайлан [ишиглэдэг] гэдэг үг үгсийн сангийн хувьд сонирхолтой жишээ бөгөөд утгыг нь хотод өссөн хүн мэдэхгүй болжээ. Сүүтэй ямааг үнээ мэт дэлэнтэй, дуу нь бүрээ мэт уянгалдаг. Ишгийг түгжир хув, орог саарал, захад явдаг загал буурал гэж зүс, ашаар нь магтжээ. Эцэст нь малын өвчин хамуу, годронгүй үржилт сүргийнхээ амар мэндийг эрж магтжээ. С.Үржинханд ямаан сүргийг магтахдаа өмнөх уламжлалаар зүс шинжээр нь:

Сээтэн босоо чихтэй

Сэргэлэн цовоо байдалтай

Шингэн нарийхан дуутай

Уураг сүү арвинтай

Удам төрөл олонтой... гээд хүн бүхний мэддэг дүрслэлийг “давтсан”.

Харин:

Хонийг баахан дагууламтгай

Хорооны мухар эзлэмтгий

Нөмрийг түргэн оломтгой

Нөхрийг жаахан гадуурхамтгай

гээд донжтой магтахад нь сонссон бүхэн нээрээ л тийм ааш авиртайдаа гэж хөхин баясаж инээлдэж байдаг. Энд магтаалчийн уран цэц, урлах авьяас, дүр бүтээх чадвар, үг ончтой зөв дүрслэх авьяас билиг нь тод илэрч байгааг онцлон тэмдэглэе. Тэр тэрхүү чадвараа гүнзгийрүүлэн:

Хажиг уцаар маягтай

Хавьтиж ойртосноо мөргөх шиг

Хазаж чангааж тавих шиг

Асга хаданд авирамтгай

Амтат ургамлыг шилэмтгий...

Тэвгэн бутан сахалтай

Тэсвэр хатуужил муухантай

Торомгор хөөрхөн нүдтэй

Тодгор хөөрхөн сүүлтэй

Тохилог баян сүрэг юм... гэж цэцэлжээ.

Ямаан сүргийнхээ үр төл сайтайг нь Цэдэв тайжийн дүрслэн урласнаас шинэчлэн, цаг үедээ ойлгомжтой байдлаар дүрслэхдээ:

“Удам төрөл олонтой

Ихэр голдуу ишиглэдэг

Ишиг нь ч гэсэн төллөдөг” гэжээ.

Шинэчлэлийн хувьд:

“Хонинд ээлтэй

Хотонд бараатай” гэжээ.

Ямааны ноолуурыг нь сувд эрдэнэтэй зүйрлэн адилтгаж, ямаан сүргээ шинэ цагт дулаан саравч хашаатай хот хороонд хашдаг болсон гэсэн шинэ дүрслэлтэй боловч ямааг уламжлалт дүрслэлээр түлхүү урлажээ.

Хүснэгт №3 Үхэр сүргээ магтсан нь

Таван хошуу малын мэнд мэдэх тухай магтаалд	С.Үржинхандын Таван хошуу малын магтаалд
Уулын цаана дуулдтал урамддаг Улсын үхрийг цуглартал мөөрдөг <u>Үнээ нэгийг ч хусраадаг үгүй</u> <u>Үхэр нэгийг ч мөргөдөг үгүй</u> Бүдүүн хүзүүт их хүрэн бух Жонон эрх үйзэн идэр зайсан мэнд үү? Цэнджав, Д. (2023:58)	<u>Үхэр мөргөдөггүй</u> <u>Үнээ сувайруулдаггүй</u> Дуулга хүзүү нь бүдүүрсэн Дух магнай нь буржийсан Бөгтөр сэрвээтэй Бөөрөнхий эвэртэй Турж эцэж ядраагүй Тугалан махаа бараагүй Угтаж хэрдэг Урамдаж мөөрдөг Улаан хүрэн бухын Үржинханд, С. (2014:26)

С.Үржинханд уламжлалт дүрслэлээр бухыг эхлэн магтаж эхэлжээ. Орчин цагтаа нийцүүлэн хүүхэд залууст ойлгомжтойгоор үнээг сувайруулдаггүй бух гэсэн бол Цэдэв тайж үнээ хусраадаггүй бух гэж хуучны сайхан үгээрээ магтжээ. Уламжлалаас шинэчлэл хийж, аман яруу найргийн дүрслэлээр гүнзгийрүүлэн хүзүү нь бүдүүрсэн, дух магнай нь буржийсан, сэрвээ бөгтөр, бөөрөнхий эвэртэй, тугалан махаа бараагүй идэр залуу улаан хүрэн бухын дүр төрхийг яруу найраг болгосон нь үнэ цэнтэй байна.

Ерөөлч С.Үржинханд Монгол Улсынхаа бүх аймаг, сумдаар явж магтаж ерөөдөг улсын, төрийн их ерөөлч магтаалч тул говьд төдийлөн элбэг бус хангай зүгийн саваг сайт сарлаг, хайнаг, шинэ цагийн мах, сүүний шинэ үүлдэр сайн угсааны бух, үхэр, үнээний дүр бүтээж, монгол магтаалын төрөл зүйл дэх үхэр сүргийн “бүтцийг” баяжуулсан нь шинэчлэл болжээ. Сахлаг арвин хөөвөртэй, зузаан арьс ширтэй, сааль сүү нь арвин. Шинэ цагийн үйлдвэрт арьс шир, сүү зэрэг нь улсын хөнгөн үйлдвэрийн үнэт баялаг болж, олон түмний хэрэгцээг хангадаг, ажилчид үйлдвэрийн төлөвлөгөөг биелүүлэх гэж социалист уралдаанаар “жигүүрлэн” ажиллаж хөдөлмөрлөдөг гэсэн цоо шинэ агуулга, дүрслэл, үнэлэмж нэмж өмнөх уламжлалыг шинэчилсэн нь ХХ зууны орчин цагийн аман зохиолын сайн жишээ болжээ.

С.Үржинхандын нэг онцлог нь дүрслэлээ хошин болгож өгүүлэн, үзэгч, сонсогчдын анхаарлыг татан, нээрээ л тийм дээ гэж хөгжөөдөг урлахуйн авьяастан байлаа. Жишээ нь:

Мөөрч уулзах нь

Мөрөөдлийн шинжтэй

Мөргөлдөж салах нь

Тэмцээний чанартай

Тэргэнд орвол тэнхээтэй

Тэнэг нь хөдөлбөл адраатай гэх буюу тэнхээ чадал, зөрүүд зан нь бусад малаас ялгаатай авирыг нь:

Заанаас дутуугүй чадалтай

Загаснаас дутуугүй усчин

Зам таарвал цувдаг
Залхуу нь хүрвэл хэвтдэг
Задгай таарвал уудаг
Хээрийн бэлчээрт хэвтэмтгий
Хэлээ ороож идэмтгий
Янз бүрийн юм зажилдаг
Яс таарвал хүлхдэг
Нанжин согоо эвэртэй
Нарийн гоёмсог сүүлтэй
Хүзүү сэрвээ нь түхийсэн гэж уран цэцтэй цэцэлжээ.

Хүн бүхэн ингэж дүрслэн магтаж ерөөж чаддаггүй билээ.

Төөрч ердөө үзээгүй
Төл ердөө алдаагүй
Цувж ирдэг
Цугларч саалгадаг
Сүүн далай
Сүргийн дээж үхэр сүргийг...хэмээн гол шинж авирыг нь дүрслэхээс гадна басхүү
сул сөрөг тал нь:
Хотонд баахан оромтгой
Хороо баахан шөргөөмтгий
Хонийг баахан сэжлэмтгий ч гэдэг байх аа

гэсэн нь голыг нь олж хэлж дээ гэж үзэгч, сонсогчдыг хөгжөөн инээлгэснээ ийнхүү
авирлах чинь:

Хэвтэр бууцыг нь дулаалж байсан бол
Хэсэж хаанаас явах вэ

хэмээн муу малчин, үхэрчнийг ичээж басхүү залууст үхэр сүргийн маллагааны
зөвлөмжийг уран сайхнаар сануулах нь үзэл санааны шинэчлэл, цаг үеийн намын бодлогод
тохирох сургамжтай өнгө аяс болжээ.

Цэдэв тайж бухыг эхэлж магтаад дараа нь амбан шарыг:

“Тэргэнд явахдаа тэсгэл үгүй сайн
Түлээ ачихад тун ч сайн
Нуруу ачихад нугас шиг түргэн
Анжис тариа ачихад аюул үгүй сайн

Аль олон амбан шарууд бүхий

Идэр заан шинж бүрдэгсэд мэнд үү?” гэжээ.

Энд эр үхэр, амбан шарыг нүүдэлчин малчид тэргэнд хөллөдөг, түлээ, нуруу өвс ачдаг, говь нутгаасаа халин тариалангийн газар үхэр анжис чирдэг эрдмийг нь магтжээ. Үнээг номхон, гэлтгүй өөрөө бэлчдэг, хураах хэрэггүй цувж хотондоо ирдэг, сүү арвин, хусардаггүй сайн үүлдэртэй, дүр төрх нь хөмрүү, солжир, мухар халзан үнээ гэж дүрсэлжээ. Үхэр сүргийн магтаалын эхэнд бухаа хэргэм зэргээр хүндэтгэнэ магтсанаа төгсгөлд нь бухын гол онцлогийг:

“Ууланд очиж хөдөөлдөг улаан бүх

Улсын үхэрт тэнэн явдаг тарлан бүх” гэжээ.

Нас хүйсээр нь шөрөгтэй бяруу, шүдлэн гунж гээд үхрийн гол халдварт өвчин Мязлангүй үхрийн аймаг гэж магтжээ. Домог зүйн үүднээс ч Мязлан бол өвгөн дүртэй, Мязлангийн цагаан өвгөн¹ гэдэг үхэр сүргийг хамгаалагч гэдэг домгийн ойлголт тэр эрт үед илүү тод дүрслэгджээ.

С.Үржинхандын магтаалд бол мал эмнэлэг хөгжсөн, мязлан гэдэг өвчин утсан тул:

Хүзүү сэрвээ нь түүхийсэн

Хөх дэлэн нь сарвайсан

Хүдэр чийрэг шандастай

үхрийн дүрийн шинэчлэл бүтээсэн байна.

Цэдэв тайжийн магтаалд адуун сүргээсээ эхэлж магтдаг бол С.Үржинханд ерөөлч үхрийн дараа адуун сүргээ магтжээ.

Хүснэгт №4 Адуун сүргээ магтсан нь

Таван хошуу малын мэнд мэдэх тухай магтаалд	С.Үржинхандын Таван хошуу малын магтаалд
<u>Хулан цуглартал янцгаадаг</u> Хүлэг цуглартал унгалддаг Адуу бүхний эцэг болсон Азарга жанжин эрх үйзэн Эрдэнийн хүлэг эрх мэнд үү? Цэнджав, Д. (2023:57)	Азарга гэдэг амьтан Айхавтар сүрхий амьтан шүү Адуун сүргийн манлай болсон Араатан чонын зоригийг шантраасан Адуун сүргээ Хурд төртөл хураасан <u>Хулан цуглартал янцгаасан</u> Үүрэг хариуцлага ихтэй Үр төл сайтай

¹ **ЦАГААН ӨВГӨН** (ᠴагаан өвгөн) - Монгол угсаатны домог үлгэр, бөөгийн шүтлэг, тахилгын сан судар, “Үхэрийн үрс гаргах ёсон”, буддын шашны домог, монгол цамд Цагаан өвгөний дүр, түүнийг шүтэх зан үйл гардаг юм. Нийт монгол угсаатан энэ дүрийг шүтэж ирсэн учраас нутаг нутгийн аялгуугаараа нэрлэдэг. Тухайлбал: халхад: Цагаан буурал өвгөн, Цагаан өвгөн, Мязлангийн цагаан өвгөн, Дэлхийн цагаан өвгөн, Мянган нүдэт, ордост Мязлангийн цагаан өвгөн; Буриадад: Саган үбгэн, Цагаан авга, Цаган Аава (Белый старец); халимагт: Цалан буурл өвгн, Цаган буурл өвгн, Цагаан авга, Делкян цаган өвгөн, Делкян эзэн, Ик бурхн, Жилийн эзэн (Джилийн эзн), Жилийн ноён (Джилийн нойон), Цагаан авга, Газрын эзэн, Дэлхийн цагаан өвгөн, Хөгшин Богд, Ертөнцийн эзэн, Бүх газар дэхийн эзэн, Их бурхан, Нуудг бурхан (Кочующий бурхан) гэх мэтээр нэрлэдэг.

	Үнэт эцэг мал шүү Үржинханд, С. (2014:28)
--	--

гэж аль аль азаргаа эхлэн магтжээ. Сүргийн бэлчээрт, уяа зэлэн дээрээ азарга янцгаахад ээрэм говь, талын зэрлэг цовоо хулангийн “эмэгчин” нь хүч тэнхээ ихт хулангийн азаргаа ч “үл тоон” унгалдах, сэрвэлзэх, янцгаах гэдэг монгол үндэстний гайхалтай, уран зохиолын дүрслэл болж чаджээ.

Цэдэв тайж магтаалдаа адуун сүргийнхээ алхаа гишгээгээр нь: жороо сайвар, тархай хатир, арилжиж хатирдаг цавьдар морь гэсэн бол зүс, ааш, эдэлгээ уналгын шинжээр нь уургын алаг урт шарга, хонины бор, хотгор зээрд, хаздаг хар, хайрдаг буурал, адуу бүхний эх болсон аль олон гүү гээд нас хүйсээр нь азарга, гүү, үрээ, байдас, унага, даага гэж тоочоод баатарлаг тууль, домог, үлгэрийн уран сэтгэмж, дүрслэлээр “ай түмэн адуун сүрэг гэсэн уламжлалт сайхан дүрслэлтэй байна. Тэгвэл С.Үржинханд гуай:

Хөөвөрлөж дэллэсэн адуунууд

Хөрвө нялх унаганууд

Хөгшин залуу гүүнүүд

Хөөрхөн цовоо дааганууд

Уядаг хурдан хүлгүүд

Уургач сайн морьдууд

Унааны тарган агтнууд

Ардаг эмнэг морьдууд

Агтлаж хөнгөлсөн үрээнүүд

Азарганд ялгасан байдсууд

Шим сайт гүүнүүд

Шинээр сургасан дааганууд

Эд бүхэн нийлж адуун сүрэг болдог юм аа гэснээр азарга азаргаар адуун сүргээ бүрэн бүтнээр нь магтсан шинэчлэл хийжээ. Адуун сүргээ нас хүйсээр нь цогц дүрсэлдэг уламжлал аль алинд уламжлагджээ. С.Үржинханд гуай адуу, морьдын зан ааш, алхаа гишгээг сэргэлэн цовоо зантай:

Сэтгэл сэргэм алхсан

Сэгсэрч зайлж жороолсон

Хазаар даран тэмүүлсэн

Халж дарж дугтарсан

Хайваж дайваж сайварласан

Хатирч өргөж арилжсан

гэж алхах, жороолох, хазаар дарах, дутрах, сайварлах, арилжих (арилжаа алхаа) гэсэн тэдгээр үйл үг нь хүүхэд залуучууд болон хэн хүнд монгол морь адууны алхааны талаарх

мэдлэг олгох бол харь хэлэнд орчуулбал утгачилж, баахан тайлбараар хагас дуу орчуулан хөрвүүлэх гэмтэй бөгөөд тэдгээр алхааны тухай үг хэллэг нь адуучны “мэргэжил мэргэшлийн” болоод үндэсний онцлог бүхий уран хэллэг болжээ.

Цэдэв тайж адуун сүргээ магтахдаа хүлэг морь нь Очир дара Богд гэгээний хүлэг, Улаан Ядамын сэтэрт хар морь, Гомбо бурхны сэтэрт хар морь, Лхам сахиусны сэтэрт хурдан зээрд, Далха бурхны сэтэрт цагаан морь, Улаан сахиусны сэтэрт хурдан зээрд, Атааны [Атаа таван тэнгэрийн болов уу] сэтэрт хөх бор морь гэж дүрсэлсэн нь уламжлалт содон дүрслэл байна. Дээр дурдсан бурхан сахиусны хүлэг унаа нь ямар өнгө зүстэй байдаг, ямар зүсмийн адуугаар ямар бурханд өргөл өгч сэтэрлэдэг ёс байдгийг нэг бүрчлэн тайлбарлан дурдсан бололтой. Тэдгээр бурхдын эш хөрөг, танка-тай тулган үзвэл бараг тэдний хүлэг унааны зүс таарах байх аа гэж бодогдож байна. Эдгээр нь уг магтаалын тухайн цаг үеийн үзэл санаатай таарч, адуун сүргээ хайрлан өсгөх, зөв сайхан эдлэн адуулах, шүтэн бишрэх хүндэтгэл төрүүлж байжээ. Нөгөө талаар Цэдэв тайжийн таван хошуу малын магтаал² нь эртний монголчуудын шүтлэг бишрэлийн зан үйл, бөөгийн ёс, сан, тахилга, тайлга, даллага, магтаал зэрэг аман билгийн шүлэг, аман яруу найргийн онцлог шинжийн нөлөөн дээр зохиогджээ.

Тэгвэл С.Үржинханд ерөөлч Цэдэв тайжаас өөр шинэ үзэл санаагаар адуун сүргээ бишрэх, хайрлах үнэлэмжийг орчин цагт шинээр үүссэн хөгжсөн хамтын хүчний нэгдэл, сангийн аж ахуй, социалист нийгмийн өмчийн “эс ширхэг бүрийг нандигнан хайрлах” үнэлэмжээр сольж, хувийнх нь өмч биш тул нийгмийн олны өмчид хайнга хүйтэн хандах сэтгэлтэн, муу адуучны гэм дутагдлыг шүүмжлэн засах, анхааруулах, дутагдлыг засах, нийгмийн хамтын өмчийг хайрлах социалист нийгмийн үеийн үнэт зүйлийн үнэлэмж, нам төрийн тэр цагийн бодлого, коммунист үзэл суртлын зарчим хандлагатай нягт холбож, үзэл санааны шинэчлэлт хийсэн магтаал зохиосон нь цаг үедээ чухал нийцтэй болжээ. Энэ бүхнийгээ дүрслэхдээ:

“Эдэлгээ уналгаас шалтгаалсан

Эмгэг зовлон олсон

Харцага нурууг нь авсан

Хазгар доголлон болгосон

Харшааж эцээж хаясан

Хань ижлээс нь салгасан

Хайш яайш байдал ч

Харагдаж л байх юм байна

Эдэлж унахдаа хайрлаж бай

Эмзэг өвчнөөс сэргийлж бай

² М.Цэдэв тайж энэхүү магтаалаа өөрөө зохиосон уу? Нутгийнхаа ерөөлч, магтаалчдаас бичгийн хүн, сурвалжит тайжийн хувьд сударт тэмдэглэн үлдээсэн үү? хэмээн эргэлзсэн асуудал дэвшүүлж болох юм. Гэвч өдгөө Цэдэв тайжийн удам, зохиолч, сэтгүүлч Долгорын Цэнджав, Долгорын Чулуунбаатар нарын шилдэг бүтээл, бичих туурвих гоц авьяас нь Цэдэв тайжаас уламжилсан удамшил, хурц билиг харагдах тул яах аргагүй Цэдэв тайж “Таван хушуу малын мэнд мэдэх тухай” магтаалыг зохиосон байна гэхэд маргах хүн гарахгүй байх аа.

Эмнэг догшныг нь сургаж бай

Эдэлгээ унаанд оруулж бай

Эзний ёсоор хандаж бай”³ гэсэн.

Магтаал хэмээх аман зохиолын төрөл нь нь бүх л сэдвээр зөвхөн магтах л үүрэгтэй гэж ойлгож ирсэн уламжлалыг С.Үржинханд магтаалч харин зарим малчдын сул тал, дутагдлыг нь хурц шүүмжлэх, зөвлөн анхааруулах, нам, засаг, нэгдлийн бодлого чиглэлийг сурталчлах, уриалан дуудах үзэл санааны өөрчлөлт хийсэн нь цаг үедээ тохирсон агуулгатай, сургамжтай төдийгүй илгээлтийн эзэн олон залуу малчдад санаа сургамж өгч, сурган зөвлөж байжээ.

Хүснэгт №5 Тэмээн сүргээ магтсан нь

Таван хошуу малын мэнд мэдэх тухай магтаалд	С.Үржинхандын Таван хошуу малын магтаалд
<u>Хүмүүний чинээ бөхтөй</u> Хүрэн чинээ тавагтай... Урт гэгч хүзүүтэй Амьтнаас ангид дуутай Арван хоёр жилийг багтаан төрсөн Буур ат болд нягт хурц билигт Ингэ, тором, тайлаг хийгээд Ер тэмээний аймаг бүхий мэнд үү? Цэнджав, Д. (2023:58)	<u>Босоо бөх нь буугаагүй</u> Ботгон махаа бараагүй Буйл нь сайн Бурантаг нь шинэ Бууран тэмээнийхээ Бусад ижил сүргийг нь хэлбэл Буурал мэлзэн хоншоортой Бужгар өвдөг зогдортой... Урт удаан настай Уран цээлхэн хүзүүтэй Уянгалаг сайхан дуутай <u>Ширээ тэгш бөхтэй</u> Шил дүүрэн мяндастай Шилдэг зөөлөн ноостой Шилэн тунгалаг нүдтэй Шим сүү арвинтай Өндөр гуалиг чацтай Өргөн зузаан тавхайтай Өөртөө богинодсон сүүлтэй Өвлийн хүйтэнд тэсвэртэй Өл хоол даахдаа сайн Алтан шаргал зүстэй Алс хол бэлчээртэй Аварга том алхаатай Үржинханд, С. (2014:29-30)

Цэдэв тайжийн магтаалд тэмээн сүргийн аян жин тээх явдал, хүч тэнхээг нь тухайн цагийн өнгө, очих хүрэх гол газрын хэмжээ зайгаар нь:

Зуугаас нааш газрыг

Зуу мянгаар товчлон ирдэг

Бээжингээс нааш газрыг
Бэрх хатуужлаар яваад ирдэг
Очих гэсэн газартаа очдог зоригтой
Хүрэх гэсэн газартаа хүрдэг чадалтай...
Арьс шир, алт мөнгөний алийг ч
Ачуулаад зүдэрдэггүй

гэж Зандан зууд мөргөх, Бээжин очих зэргээр хол ойрын зайг хэмжсэн бол С.Үржинханд уламжлалт дүрслэлийг цаг үед нь тааруулан шинэчлэхдээ:

Алс хол бэлчээртэй
Аварга том алхаатай
Аянд явахад итгэлтэй
Ачиж явахад түшигтэй
Айл хотоо нүүлгэдэг
Аргал усаа татдаг
Ач тусыг нь хэлээд барахгүй

хэмээн ахуй амьдрал, аян жинд итгэлтэй, хүчтэй, түшигтэй үүрэг хэрэглээний талаас нь дүрсэлжээ.

С.Үржинханд магтаалч тэмээний бие махбодын онцлог нь:

Хаварт даардаг
Хавсарганд хэвтдэг
Халуунд салхиддаг

шинжтэйг тэмээчин бүрд сануулж, үзэгч сонсогчийг баясгах хошин өнгө аясаараа:

“Ядарсан хүнд алхаа нь ширүүн
Яарсан хүнд явдал нь удаан” гэжээ.

Хуучин цагт хувийн өмчөө хайрлан өсгөдөг байсан бол нэгдэлжсэний дараа хамтын өмчид хүйтэн цэвдэг сэтгэлээр хандах муу тэмээчнийг шүүмжилж:

Зарим нэгдлийн тэмээний
Захад нь ороод харж байвал
Гараар барьж сураагүй
Гарч цааш зугтаасан
Ноос үсээ авхуулдаггүй
Ногтолж бурантаглаж үзээгүй
Ороо морь шиг хулжсан

Орсон буур шиг хүрхэрсэн

Онцгой догшин олон л байх юм

гэж ичээн шүүмжлээд угийн тэмээчин удмын малч зангаараа:

Бага насанд нь унаа эдэлгээ үзүүлж бай

Уналга хөсөгт сургаж бай

гэж сануулсан нь аанай л уламжлалт тэмээний магтаалд үзэл санааны өөрчлөлт нэмж, мал аж ахуйд тэргүүн туршлага нэвтрүүлэх, ахмад хашир тэмээчдээс суралцах, ах захын ёсоор сургах, залуу үеийг халамжлан хүмүүжүүлэх тухайн цагийн нам төрөөс дэвшүүлсэн бодлого, шинэ үзэл санааг магтаалдаа дүрсэлсэн нь басхүү шинэчлэлт болжээ.

ДҮГНЭЛТ

Мэндбаярын Цэдэв (1892-1938) тайж, ерөөлч, магтаалч Сандагийн Үржинханд (1910-1993) (Үржинханд.С, 2014) хоёр нэг нутгийн аман билигтэн, соёлын өв тээгч, ардын яруу найрагчид байжээ.

С.Үржинханд гуай М.Цэдэв тайжийн магтаалыг бага наснаас өөрийнх амнаас юм уу эсвэл тэр магтаалыг дамжуулагч магтаалч ерөөлчдөөс сонсож өссөн нь ерөөлч, магтаалч болох хүслийг нь бадрааж, шинэ цагийн шилдэг магтаалч, ерөөлч болоход нь шууд нөлөөлсөн гэж үздэг. Цэдэв тайжийн “Таван хошуу малын мэнд мэдэх тухай магтаал”-ын уран яруу дүрслэл үг хэллэг нь С.Үржинхандын цээжинд бага залуу насанд нь хоногшин үлдсэн тул хожмын бүтээлийнх нь сэдэл, уран чадварлаг бичлэгийнх нь хөрс суурь болжээ. Гэхдээ уламжлалт тэрхүү магтаалыг нь хуулж давтаагүй. Хурц авьяас билгээрээ ижил төстэй сэдвээр “Таван хошууны магтаал”-ыг өөрөө чадварлаг зохиож чадсан нь онцлог байна. Харин М.Цэдэв тайжийн магтаал судраар, бичгээр, С.Үржинхандын магтаал бичгээр, ном хэвлэл, радио, телевизийн нэвтрүүлэг өдгөө цахим мэдээллээр дэлхий даяар тархан уламжлагдаж байгаа нь аман зохиолын шинэ цагийн нэгэн тод үзэгдэл болжээ. Түүний бүтээлийг амьдарч байсан цаг үетэй нь холбон судлах, шинэ цагийн ерөөлч, магтаалчийн хувьд нийгмийн захиалгыг хэрхэн биелүүлж байсныг нь ажиглан судлахаас гадна урын санг нь өмнөх үе уламжлалтай нь холбон судлах тусам ур чадвар нь тодорч байна.

A study on 'the praise of the five horned livestock

Chultemsuren Rinchin 

*Professor of the Department of Literature,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

Nadmid Batbileg 

*Ph.D, Lecturer of the Department of Literature,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

Abstract: Praise poetry occupies a central and distinctive position within Mongolian oral literature. As an integral component of the intangible cultural heritage of nomadic pastoral Mongolians, praise poetry articulates verbal exaltation and symbolic benediction of mountains and waters, dwellings, livestock, and material objects. This practice embodies the distinctive mentality of the Mongolian people. The nationally specific characteristics of Mongolian oral literature—together with nomadic modes of cognition and established systems of symbolic representation—are particularly evident in this genre.

Beyond the extensive corpus of praise texts preserved in oral poetic form, successive generations of celebrated praisers have emerged from among Mongolian and Mongolic-speaking communities, attesting to the historical continuity and cultural significance of the genre. Among these figures is S. Ürjinkhand (1910–1993), a native of Gurvansaikhan sum in present-day Dundgovi Province, who was widely recognized as a master benedictioner and praiser. His repertoire encompasses a broad thematic range, including “Household Benediction,” “Wedding Benediction,” “Praise of the Five Kinds of Livestock,” and * “Praise of the Cooperative.” He is justifiably regarded as one of the most accomplished Mongolian benedictioners and praisers of the twentieth century.

This article analyzes the principal thematic concerns, figurative imagery, and compositional strategies of Ürjinkhand’s “Praise of the Five Kinds of Livestock,” situating the text within a framework of tradition and innovation. Furthermore, it undertakes a comparative examination of this work alongside the manuscript praise text entitled “On Inquiring after the Well-being of the Five Kinds of Livestock,” transmitted from the nobleman M. Tsedev (1892–1937), a native of Gurvansaikhan sum in present-day Dundgovi Province, formerly belonging to the Daichin Beise Banner of Tüsheet Khan Province. Through this comparative analysis, the study elucidates both the continuity of inherited forms and the processes of transformation within the Mongolian praise tradition.

Keywords: S. Ürjinkhand, five kinds of livestock, praise poetry, benediction, Mongolian oral literature

Ном зүй - References

А.Д.Цендина, Р. (2025). Ц.Дамдинсүрэнгийн өдрийн тэмдэглэл. Улаанбаатар.

Баясгалан Т. (2023), Монгол ардын магтаалын уран сайхны онцлог //Монгол аман зохиолын туурвил зүй, (х. 128-173). Улаанбаатар.

Гаадамба, Ш. Сампилдэндэв, Х. (1988), Монгол ардын аман зохиол, (х.103-119), Улаанбаатар.

- Дулам, С. Нандинбилиг, Г. (2007), Монгол аман зохиолын онол, I, (271-300), Улаанбаатар
- Катуу, Б. (2011). *Таван хошуу малын магтаал*. Баяд ардын аман зохиол (х. 521). Улаанбаатар.
- Монгол ардын ерөөл магтаал (2006), Монгол бичгээр, Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хороо, (551 х.), Хөх хот
- Нямбуу, Х. (1983). *Таван хошуу малын магтаал*. Монгол ардын ерөөл магтаал (х. 90–92). Улаанбаатар.
- Өлзийхутаг, Ц. (1989). *Таван хошуу малын магтаал*. Монгол ардын ерөөл магтаал (х. 23–29). Улаанбаатар.
- Үржинханд, С. (2014). *Таван хошуу малын ерөөл [магтаал]*. Ардын ерөөлч магтаалч Сандагийн Үржинханд (х. 24–31). Улаанбаатар.
- Чүлтэмсүрэн, Р. Ганболд, Д. нар (2022), Сэцэн ханы аман билиг. (Х.334-406). Улаанбаатар
- Цэнджав.Д. (2023). In *Таван хошуу малын мэнд эрэх судар. Утга зохиолын судлал шүүмжлэл, бүтээл туурвилын эмхэтгэл* (pp. 54-59). Улаанбаатар.
- Цэрэндорж, Ц. (2002), Хуур магтаалын бадралт уянга, (3-292 х.). Улаанбаатар.
- Цэрэнсодном, Д. (2012), Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг. (х.135-167), Улаанбаатар